

# “ДОРВОЛЖИЙН БЭЛ” ХХК

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
19-р хороо 33-04 тоот  
Утас: +976 95953648  
2023-04-26 № 07

## “СҮХБААТАР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР”-д

### Тодруулга авах тухай

Манай компани танайхаас зарласан “Гэр төсөл хэрэгжүүлэх” нийлүүлэх СБАОНӨГ/202301060 тоот тендерт оролцож байгаа ба Захиалагчийн техникийн тодорхойлолтод :

1. Гэр төсөл хэрэгжүүлэх техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын 1-р хүснэгтэнд Монгол гэрийн MNS 0370:2003, MNS 0370:2011 стандартын дагуу үйлдвэрлэсэн байна гэсэн.
  2. Техникийн тодорхойлолт тавигдах шаардлагын 2,3 дугаар хүснэгтэнд Монгол гэрийн эсгий MNS5801:2007 стандарт шаардлага хангасан байна гэсэн.
  3. Техникийн тодорхойлолт тавигдах шаардлагын 4,5 дугаар хүснэгтэнд Гэрийн бүх бүрээс нь MNS0414:2012 стандарт шаардлагад нийцсэн байх гэсэн.
1. Монгол гэрийн MNS 0370:2003, MNS 0370:2011, Монгол гэрийн эсгий MNS5801:2007 стандартууд нь одоо мөрддөггүй хуучин стандарт шаардлага билээ. Хуучин буюу MNS 0370:2003, MNS 0370:2011, MNS5801:2007 стандарт шаардлагын дагуу үйлдвэрлэсэн Монгол гэр нь Захиалагчийн шаардлагад нийцэх үү? Шинэ буюу Монгол улсын хуулийн дагуу Стандарт хэмжил зүйн газараас олгосон Монгол гэрийн MNS 0370:2021, Монгол гэрийн эсгий MNS 0296:2012 стандарт шаардлагуудын дагуу үйлдвэрлэсэн байх нь Захиалагчийн шаардлагад нийцэх үү? Аль стандарт шаардлагын дагуу үйлдвэрлэсэн Монгол гэрийг шаардлагад нийцсэн гэж үзэх вэ?
  2. Монгол гэрийн бүрээс MNS0414:2012 стандарт болон дээрх стандарт шаардлагуудыг хангасан гэж хэрхэн нотлох вэ?
    - Тендерт оролцогч нь техникийн шаардлагыг харьцуулсан хүснэгтээр хийж уг хүснэгтэндээ дээрх стандартыг хангасан байна гэж бичсэнээр нотлогдох уу?
    - Стандарт шаардлагуудыг хангаж буй тухай албан мэдэгдэл ирүүлснээр нотлогдох уу?
    - Монгол улсын хуулийн дагуу Стандарт хэмжил зүйн газараас олгосон MNS 0370:2021, MNS 0296:2012, MNS0414-1:2012, MNS0414-2:2012 стандартын Тохирлын гэрчилгээгээр нотлогдох уу?

Энэ талаар тодруулга гаргаж байна.



“ДОРВОЛЖИЙН БЭЛ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /Н.ЭНХЦЭЦЭГ/



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ КОМПАНИУДАД

СҮХБААТАР АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас, Факс: 70510010, 70510020

2023.04.28 № 269  
танай 2023.04.28 -ны № 28 -Т

Тодруулга хүргүүлэх тухай

Манай байгууллагаас зарласан СБАОНӨГ/202301060 дугаартай Гэр төсөл хэрэгжүүлэх барааны тендерт "Дөрвөлжийн бэл" ХХК-аас 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Тодруулга авах тухай 07 тоот албан бичиг ирүүлсний дагуу дараах тайлбар тодруулгыг оролцогч компаниуд хүргүүлж байна.

1. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан Монгол гэрийн эсгийн хуучин стандарт болон шинэчлэгдсэн стандартыг аль нь ч шаардлагад нийцсэн гэж үзнэ
2. Монгол гэрийн хийцийн стандартыг Стандарт хэмжил зүйн газрын Тохирлын гэрчилгээгээр /түүнтэй адилтгах/ нотолж ирүүлнэ. Үйлдвэрлэгчээс дамжуулан нийлүүлэх бол үйлдвэрлэгчээс холбогдох нотлох баримтыг авч тендерийн материалд хавсарган ирүүлнэ.

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ө.ТАЙВАНСАНАА

